



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/153

Арвайхээр

┌ Ээлжит цэрэг татлага явуулах тухай ┐

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны м/н 250 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2020 оны н/65 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2020 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын ажлыг 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 04 дүгээр сарын 29-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. “Цэрэг татлага явуулах хуваарь”-ийг нэгдүгээр, “Эрүүл мэндийн үзлэг хийх эмч нарын комиссын бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар, “Цэрэг татлагын үйл ажиллагаанд шаардагдах төсөв”-г гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Цэрэг татлагын товчооны дарга (Ц.Ганболд)-д ДААЛГАХ нь:

а. Цэрэг татлагын ажлыг Цэргийн штабын даргаар ахлуулж батлагдсан хуваарийн дагуу тухайн сумдад зохион байгуулан ажиллуулах.

б. Цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж, цэрэг татлагын үед сахилга, дэг журам, техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулах бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

в. Аймаг, орон нутаг дахь цэрэг халалт, татлагын үйл ажиллагааны үеэр ариутгал, халдваргүйжүүлэлтийн горимыг сахиж, аймгийн онцгой комиссын шийдвэрийг чанд мөрдөн ажиллах.

4. Эрүүл мэндийн үзлэгээр явах эмч нарыг үүрэг даалгавраар хангаж, эмнэлгийн фургон УАЗ-452 авто машин /1 нэгж/-ийг 2020 оны 04 дүгээр сарын 19-ны өдрөөс 04 дүгээр сарын 29-ны өдрийг хүртэлх хугацаанд гаргаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал (Э.Хүдэрчулуунд)-д даалгасугай.

5. Цэрэг татлагын үйл ажиллагаанд зарцуулах 3.785.520 (гурван сая долоон зуун наян таван мянга таван зуун хорин) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100329

Аймгийн Засаг даргын 2020 оны 04  
дугаар сарын 13-ны өдрийн 115 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт




ЦЭРЭГ ТАТЛАГА ЯВУУЛАХ ХУВААРЬ

Д/д	Сум	Он, сар, өдөр	Цаг	
			Эхлэх	Дуусах
1.	Арвайхээр	2020.04.19-20	08.30	18.00
2.	Хархорин	2020.04.21-22	08.30	18.00
3.	Өлзийт	2020.04.23	08.30	18.00
4.	Есөнзүйл	2020.04.24	08.30	18.00
5.	Бүрд	2020.04.25	08.30	18.00
6.	Баян-Өндөр	2020.04.26	08.30	18.00
7.	Сант	2020.04.27	08.30	18.00
8.	Баянгол	2020.04.28	08.30	18.00
9.	Төгрөг	2020.04.29	08.30	18.00

Аймгийн Засаг даргын 2020 оны .04  
дугаар сарын .13.-ны өдрийн .15 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

ЦЭРЭГ ТАТЛАГЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ ХИЙХ ЭМЧ  
НАРЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

№	Эмч нарын хуваарь	Эмч нарын нэр
1.	Ерөнхий эмч	Г.Дашжанцан
2.	Нүдний эмч	Б.Чанцалдулам
3.	Чих, хамар, хоолойн эмч	Б.Даваасүрэн
4.	Мэдрэлийн эмч	Б.Энхбаатар
5.	Сүрьеэгийн эмч	Т.Отгон
6.	Дотрын эмч	Д.Эрдэнэсүвд
7.	Мэс заслын эмч	Б.Оюунбилэг
8.	Арьс өнгөний эмч	Г.Мягмарсүрэн



Аймгийн Засаг даргын 2020 оны 04 дугаар сарын 13-ны өдрийн 153 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

2020 ОНЫ НЭГДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

1. Шатах тослох материалын тооцоо

Д/д	Зориулалт	Машин		Шаардагдах ШТМ		Нэгжийн үнэ			Бүгд үнэ		Нийт үнэ
		марк	тоо	явах км	А-92 /л/	Масло /л/	А-92 /л/	Масло /л/	А-92 /л/	Масло /л/	
1	9 сумдаар тойрч цэрэг татлага явуулах	Ланд-105	1	750	150	1	1830	10000	274.500	10000	284.500
		Фургон машин	1	750	150	1	1830	10000	274.500	10000	284.500
2	Цэрэг татлагын товчоонд шаардагдах	ланд-105	1	200	44	-	1830	-	80.520	-	80.520
3	Аймгаас УБ-т цэрэг хүргэх буцах	Приус-20	1	1000	100	-	1830	-	183.000	-	183.000
	<b>Дүн</b>		<b>3</b>	<b>2700</b>	<b>444</b>	<b>2</b>	<b>1830</b>	<b>10000</b>	<b>812.520</b>	<b>20000</b>	<b>832.520</b>

2. Томилолтын төсөв.

д/д	Албан тушаал	хүний тоо	ажиллах хоног	нэг хоногийн томилолт	Улаанбаатарт			Нийт томилолтын зардал
					Хүний тоо	ажиллах хоног	нэг хоногийн томилолт	
1	Офицер	3	10	12000	2	5	16000	160.000
2	Эмч	8	10	12000	1	5	16000	80.000
3	Жолооч	2	10	12000	-	-	-	240.000
	<b>Дүн</b>	<b>13</b>	<b>10</b>	<b>12000</b>	<b>3</b>	<b>5</b>	<b>16.000</b>	<b>240.000</b>

3. Хоолны төсөв.

Д/д	Зориулалт	Хооллох хүний тоо	Хэдэн удаа	Нийт хүн	Нэг өдрийн хоолны үнэ	Нийт үнэ
1	Цэрэг татлагын комисс	13	2	26	8000	208.000
2	Цэрэг хүргэж ирсэн офицеруудыг хооллох	12	5	60	8000	480.000
3	<b>Дүн</b>	<b>25</b>	<b>7</b>	<b>86</b>	<b>8000</b>	<b>688.000</b>

4. Бусад зардал

№	Материалын нэр	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1.	Ариутгал, халдваргүйжүүлэлтийн материал /Маск, гар ариутгах бодис/	Маск 1200 Гар ариутгагч 1500	Маск-200 Гар ариутгагч-150	465.000
				<b>465.000</b>

Цэрэг татлагын нийт зардал – 3.785.520